**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2021 оны 04 сарын 15 өдөр    Дугаар A/181    Чингис хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж авах төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Дарга: | Г.Лхагвахатан | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга: | Н.Үнэнбат | Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн |
| Гишүүд: | Э.Дэлгэрмаа | Эрүүл мэндийн газрын хөрөнгө оруулалтын төлөвлөлт, эмнэлгийн хэрэгслийн хангамж хариуцсан мэргэжилтэн |

2. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

3. Ажлын хэсгийн зохион байгуулах төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА    Ц.ИДЭРБАТ

231011747